



Joint Mongolian-German Project
International Trade Policy/WTO

Ministry of Industry and Trade – German Technical Cooperation
C.P.O.Box 1264 Ulaanbaatar 210613 Mongolia
Phone: +976-11-315464 Fax: +976-11-315955 Mail: trade@gtz-mongolia.org



Албан болон бусад баримт бичгүүд № 4

**Дэлхийн бизнес ба
ДХБ-ын үүргийн тухай**

“ДХБ-аас Дэлхийн бизнест зориулсан гарын авлага”

НОМНООС АВСАН ИШЛЭЛ

ЗОХИОЛЧИД

Карол С. Жорж, Стефен Ж. Орава

Орчуулсан Н. Алтаннавч

Хэвлэн нийтлэгч ба зохиогчийн эрхийг эзэмшигч Cameron May пүүсийн зөвшөөрөлтэй хэвлэв.
Cameron May Ltd. 69-71 Bondway, London SW8 1SQ, United Kingdom

Англи хэлний эхийг хэвлэн нийтэлсэн пүүс зохиогчийн эрхээ авч үлдэх болно.

© Cameron May 2002


DIRC

Хөгжлийн Мэдээллийн Төв



Агуулга

1. Оршил.....	2
2. ДХБ гэж юу вэ?.....	3
3. ДХБ-ын гишүүд хэн байдаг вэ?	3
4. ДХБ-ын хэлэлцээрийн үндсэн дүрэм журам нь юу вэ?	4
5. ДХБ-ын олон талт худалдааны хэлэлцээрүүд гэж юу вэ?	4
6. Одоо мөрдөгдөж буй ДХБ-ын эрх, үүрэг цаашид өөрчлөгдөх үү?.....	6
7. ДХБ-ын үүрэг хариуцлагыг хэрхэн мөрдлөг болгодог вэ ?.....	6
8. Гишүүд хоорондын маргааныг хэрхэн шийдвэрлэдэг вэ?	7
9. ДХБ-ын албадан мөрдүүлэх дүрэм үр дүнтэй байж чадсан уу?.....	9
10. ДХБ-ын дүрэм журам хувийн компаниудад яагаад чухал вэ?	9
10.1. ДХБ-ын дүрэм журам ба бизнес төлөвлөлт	9
10.2. ДХБ-ын дүрэм журам ба дотоодын шүүх ажиллагаа	10
10.3. Олон улсын шүүх ажиллагаа: ДХБ-ын Маргаан шийдвэрлэх тогтолцоо.....	11
10.4. Хууль боловсруулах үйл явцад нөлөөлөх буюу бодлогын өмгөөлөл	13



ЭНЭ НОМЫГ
НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ
ФОРУМААС
ХАНДИВГАВ

1. Оршил

Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ) нь олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын талаарх дэлхий нийтийн дүрэм журмуудыг тогтоож, хэрэгжүүлэн, мөрдүүлдэг Засгийн газар хоорондын олон улсын байгууллага юм. Эдгээр дүрэм журмууд нь хувийн компаниудын гадаад дотоодын зах зээл дээрх үйл ажиллагаанд олон чухал нөлөө үзүүлдэг. Энэхүү эмхэтгэлийн зорилго нь ДХБ-ын дүрэм журмууд хувийн компаниудад ямар ашиг тустай байж болох, эдгээр ашгийг хэрхэн олох тухай ойлголт өгөхөд оршино.

ДХБ-ын дүрэм журмуудын хамрах хүрээ өргөн бөгөөд улам тэлсээр байна. Аливаа бараа бүтээгдэхүүн тухайн улс орны хилээр нэвтрэх бүрийд эдгээр дүрэм журам мөрдөгддөг. Хөдөө аж ахуй, нэхмэл сүлжмэл зэрэг эмзэг салбаруудын хувьд эдгээр нь тусгай дүрэм журмаар зохицуулагдана; үйлчилгээ, түүний дотор санхүү, харилцаа холбооны үйлчилгээнд тусгай заалтууд байдаг; эдгээр нь оюуны өмчийг хамгаална; техник, эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарт мөрдөхөд тэдгээрийг удирдлага болгоно; Засгийн газрын худалдан авах ажиллагааг зохицуулна; дампингийн¹ эсрэг, нөхөн тэгшитгэх² болон худалдааны бусад хамгаалалтын арга хэмжээний тухай дэг журмуудыг тогтоож байна. ДХБ-ын гишүүд хөрөнгө оруулалт, үйлчилгээ, хөдөө аж ахуй, оюуны өмч болон бусад асуудлаар ДХБ-ын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрмэнд өөрчлөлт оруулж, хүрээг нь өргөжүүлэх тухай хэлэлцээ, ярилцлагын төрөл бүрийн үе шатанд оролцож байна. Түүнчлэн ДХБ-ын хүрээнд хөдөлмөр, байгаль орчин, өрсөлдөөний бодлогын талаархи шинэ дүрэм боловсруулах эсэх тухай асуудлыг ДХБ-ын гишүүд хэлэлцэж байгаа билээ. 2001 оны 11 дүгээр сард гарсан Дохагийн хөгжлийн хөтөлбөрөөр эдгээр асуудлын нэлээдийг нь авч үзэх юм.

ДХБ-ын хүрээнд хүлээсэн эрх үүрэг нь хувийн компаниудын одоогийн болон ирээдүйн бизнесийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх талаар ойлголттой болсноор тэд ДХБ-ын дүрэм журмын ашигтай талыг хүртэхэд дөхөм болно. Ийм мэдлэг олж авснаар компаниуд нь ДХБ-тай холбоотойгоор гадаад дотоодын зах зээлд бүрдэх ашигтай арилжааны боломжуудыг тодруулж чадах юм. Компаниуд стратеги бизнесийн төлөвлөгөө боловсруулахдаа ДХБ-ын дүрэм журмаар олгож буй давуу талуудыг орхигдуулахгүй байвал ашиг олох боломжтой. Түүнчлэн дотоодын шүүхэд заргалдах үед хувийн компаниуд ДХБ-ын дүрэм журамд тулгуурлаж болох ба, эсхүл ДХБ-ын маргаан шийдвэрлэх үйл явцаас гарах үр дүн хувийн компаниудын үйл ажиллагаанд шууд нөлөөлөхөөр байгаа бол тэд ДХБ-ын гишүүдэд туслалцаа үзүүлж болно. Шинээр боловсруулж буй ДХБ-ын эрх, үүрэг нь компаниудын ирээдүйн үйл ажиллагаанд эерэг, сөрөг нөлөө үзүүлэх эсэхээс хамаарч эдгээр

¹ Дампинг (dumping) - хоцрогдсон загварын, хямд бараагаа өөр орны зах зээлд бөөнөөр буюу өөрийн үйлдвэрийн өртөгөөс доогуур үнээр нийлүүлэх явдал

² Нөхөн тэгшитгэх татвар (countervailing duty) - экспортлогч орны татаасыг нөхөн төлөх үүднээс импортонд ногдуулдаг татвар буюу гадаадаас орж ирээгүй бараанд ногдуулах түүнтэй адил татвар

саналыг дэмжих, эсхүл эсэргүүцэх талаар тодорхой хүчин чармайлт гаргаж болох юм.

2. ДХБ гэж юу вэ?

ДХБ бол Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээр ("ДХБ-ын тухай хэлэлцээр")-ийн дагуу тус байгууллагын Гишүүн улс орнуудын байгуулсан олон улсын байгууллага юм. ДХБ-ын тухай хэлэлцээрт ДХБ-ын Гишүүн бүх орнуудад үүрэг хүлээлгэсэн олон талт худалдааны хэлэлцээрүүд³ болон ДХБ-ын гишүүдээс зөвхөн хүлээн зөвшөөрсөн гишүүдэд үүрэг хүлээлгэх хязгаарлагдмал тооны оролцогчидтой худалдааны хэлэлцээрүүд⁴ гэж ерөнхийд нь нэрлэдэг бүлэг хэлэлцээр хавсрагдсан юм. ДХБ нь Швейцар улсын Женев хотноо байрладаг ба байнгын нарийн бичгийн дарга нарын газар, Сайд нарын Бага хурал, Ерөнхий Зөвлөлөөс үндсэндээ бүрддэг. Нарийн бичгийн дарга нарын газар нь ДХБ-ын төрөл бүрийн хэлэлцээрийн хэрэгжилтэнд хяналт тавина. Сайд нарын Бага хурал нь олон талт худалдааны хэлэлцээрүүдээр шийдвэр гаргаж, Ерөнхий Зөвлөл нь дотоод дүрэм журмыг тогтоон, маргаан шийдвэрлэх асуудал хариуцдаг. Сайд нарын Бага хурал болон Ерөнхий Зөвлөлийн аль алинд нь Гишүүн бүрийн төлөөлөгч ордог байна.

3. ДХБ-ын гишүүд хэн байдаг вэ?

Одоогоор ДХБ нь 144 Гишүүнтэй ба шинээр 27 орон Гишүүнээр нэгдэн орох өргөдөл өгөөд байна. Улс орон болон түүнтэй дүйцэхүйц статустай этгээд ДХБ-д Гишүүнээр элсэж болдог. ДХБ-ын гишүүдийн дийлэнх нь тусгаар тогтносон улс орон байх боловч, үүнд хамаарахгүй жишээ бол Европын холбоо, Гонконг болон Тайвань гэсэн гишүүд юм. ДХБ-д Гишүүнээр элсэх сонирхолтой улс орон нэгдэн орох үйл явцаар дамжин түүнд нэгдэх өргөдлөө гаргаж болдог. ДХБ-ын шинэ Гишүүн тус бүр ДХБ-ын хүчин төгөлдөр дүрэм журмыг мөрдөхийг хүлээн зөвшөөрч, худалдааны аливаа саад тотгорыг багасгах үүрэгтэй байдаг тул (гишүүдэд нь "санал болгож буй буулт" гэж нэрлэдэг) нэгдэн орох үйл явцад удаан хугацаанд үргэлжлэх хэлэлцээ хийх шаардлага гарах нь олонтой. Шинээр элсэж буй Гишүүний нэгдэн орох нөхцөлд хэлэлцээний үр дүнг тодорхойлж, худалдааг чөлөөлөх талаар тухайн шинэ Гишүүний хүлээх үүргийг заадаг байна. Эдгээр үүргийг нэгдэн орох үед, эсхүл тогтоосон тодорхой хугацаанд багтааж биелүүлэх ёстой юм. Хувийн эрх ашгаа төлөөлж буй этгээд нь нэгдэн орох өргөдөл өгсөн аливаа оронтой хэлэлцээ хийх үед өөрийн сонирхож буй байр сууринд засгийн газраа баттай зогсохыг ятгаж, засгийн газартайгаа уялдаа холбоотой ажиллах замаар өөртөө ашигтай нөхцөл бүрдүүлэн авах боломжтой юм.

³ Multilateral trade agreements

⁴ Plurilateral trade agreements

4. ДХБ-ын хэлэлцээрийн үндсэн дүрэм журам нь юу вэ?

ДХБ-ын хэлэлцээр бүр нь ерөнхийдөө үл ялгаварлан гадуурхах хоёр зарчим дээр үндэслэгддэг. Эдгээр зарчим нь гишүүн бүрийн зах зээлд бараа, үйлчилгээний (ямар улс орны гаралтайгаас нь үл хамааран) өрсөлдөх тэгш нөхцөл бүрдүүлэхийг зорьдог. Үндэстний нэн тааламжтай нөхцлийн зарчим⁵ (ҮНТН зарчим), үндэсний нөхцөл⁶ (ҮН) хоёр нь үл ялгаварлан гадуурхах суурь хоёр зарчим юм. Ил тод байх өөр нэг зарчим нь худалдааны өрсөлдөөний нөхцлийг тэгшитгэх зорилготой аж.

ҮНТН зарчмын дагуу аливаа Гишүүн нь өөр Гишүүнээс оруулж буй импортын бараа, үйлчилгээнд бусад аль ч улс орноос (ДХБ-ын Гишүүн эсэхээс үл хамааран) импортолж буй бараанд үзүүлсэн нөхцлөөс дутуугуй таатай нөхцөл олгохыг шаарддаг. Ингэснээр (эдийн засгийн бусад зохицуулалт хийгээгүй тохиолдолд) Гишүүн аль ч орон өөр нэг Гишүүн орныг илүүд үзэж тухайн бараанд тарифыг багаар тогтоох явдал гарахгүй юм. Харин илүүд үзсэн тохиолдолд тухайн бага тарифыг нэн даруй, ямар ч нөхцөлгүйгээр бусад бүх гишүүдэд ногдуулахыг тэд шаардах эрхтэй. ҮНТН зарчим нь зөвхөн тарифт хамаараад зогсохгүй гаалийн үйл ажиллагаа, захиргааны дотоод журмыг удирддаг дүрэм зэрэг гишүүдийн хяналтанд хамрах худалдааны нөхцөлд ч мөн үйлчилнэ.

ҮН буюу үл ялгаварлан гадуурхах хоёр дахь зарчим нь ҮНТН зарчимтай төстэй боловч импортолж буй бараа, үйлчилгээнд (үйлчилгээний холбогдох үүрэг амлалт авсан тохиолдолд) хамрах нөхцлийг тухайн орны дотоодын бараа, үйлчилгээнд хамардаг нөхцөлтэй харьцуулж үздэг. Өөрөөр хэлбэл аливаа Гишүүн нь өөр нэг Гишүүний бараа, үйлчилгээг өөрийн бараа, үйлчилгээнээс дутуугуй таатай нөхцлөөр хангах ёстой аж. ҮН-ийн хүрээ нь ҮНТН зарчмын нэгэн адил өргөн бөгөөд татварын арга хэмжээ, захиргааны дотоод журам, маркетингийн шаардлага зэргийг багтаадаг.

Эцэст нь, олон улсын худалдаанд нөлөөлөх дотоодын дүрэм журмын ил тод байдлыг (нийтэд нээлттэй байх) нэмэгдүүлэх явдал бол энэхүү эмхэтгэлд дор тайлбарлах тулгуур гурван хэлэлцээрийн зорилго юм. Ил тод байдал нь ДХБ-ын дүрэм журмын үндэс болж улс орнуудын худалдааны дүрэм журам, импортын шаардлагыг хэвлэн нийтэлж тэдгээрт өөрчлөлт орох тохиолдолд ДХБ-д мэдэгдэж байх шаардлага тавьдаг байна.

5. ДХБ-ын олон талт худалдааны хэлэлцээрүүд гэж юу вэ?

Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр (ТХЕХ) ба түүнийг дагалдах хууль тогтоомжийн оронд ДХБ-ын олон талт худалдааны хэлэлцээрүүд байгуулагдаж, 1995 оны 1 дүгээр сарын 1-нд хүчин төгөлдөр болсон юм.

⁵ Most-Favored-Nation Treatment

⁶ National Treatment Obligation

Олон талт худалдааны хэлэлцээрүүд нь тулгуур гурван хэлэлцээрээс бүрддэг. ДХБ-ын Гишүүн тус бүр эдгээр хэлэлцээрийг баталж, дотооддоо хэрэгжүүлэх шаардлагатай байдаг.

"Тулгуур" гурван хэлэлцээрт: (1-т) ТХЕХ 1994 (ДХБ-ын хүрээнд хамрах байдлаар), (2-т) Үйлчилгээний худалдааны тухай ерөнхий хэлэлцээр (ҮХЕХ), (3-т) Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээр (TRIPs) орно. Энэ гурван хэлэлцээр гурван ерөнхий салбарын худалдааг зохицуулах үндсэн зарчмыг тогтоож өгдөг бөгөөд ТХЕХ нь бараа бүтээгдэхүүний худалдааг зохицуулж, ҮХЕХ нь үйлчилгээний (үл харагдах юмс) худалдааны дүрэм журмыг тогтоогоод, харин TRIPs (Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээр)-д гишүүд хоорондын бараа, үйлчилгээний худалдаанд нөлөөлөх оюуны өмчийг хамгаалах дүрэм журмыг хамруулдаг.

ТХЕХ 1994-ийн зэрэгцээ бараа бүтээгдэхүүний худалдаанд хамрах бусад арван хоёр хэлэлцээр байдаг. Эдгээрт гаальтай холбоотой арга хэмжээ (барааны гарал үүслийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл олгох дэг журам), худалдааны тарифын бус хязгаарлалт (техникийн хязгаарлалт болон ариун цэвэр болон ургамлын хорио цээр, эрүүл ахуйн (phytosanitary) стандарт, ХАА, нэхмэлийн үйлдвэр зэрэг эмзэг тодорхой хэдэн салбарын худалдаа, худалдаанд хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх (дампингийн эсрэг авах арга хэмжээ, нөхөн тэгшитгэх татвар, хамгаалалтын бусад арга хэмжээ), худалдаатай холбогдсон хөрөнгө оруулалтын арга хэмжээ болон татаасын талаархи дүрэм журам багтдаг. Өмнөх ТХЕХ-ийн системээс ялгагдах зүйл бол эдгээр дүрэм журам нь Дэлхийн худалдааны байгууллагын Гишүүн бүрт бүрэн хамрах болсон явдал юм. Эдгээр дүрэм журмыг аливаа нэг Гишүүн мөрдөхгүй байвал үүнийг тулгуур гурван хэлэлцээрийн дүрэм зөрчсөнтэй адилаар үзэж, өөр аль ч Гишүүн дайран өдөөх эрхтэй байна.

Илүү явцуу хүрээтэй дээрх хэлэлцээрүүдийн зарчмууд ТХЕХ, ҮХЕХ болон TRIPs (Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээр)-ийн үл ялгаварлан гадуурхах, ил тод байх хоёр зарчимтай нийцдэг боловч тусгай нэг салбар, эсхүл худалдааны тодорхой асуудлыг шийдвэрлэх заалтуудыг тусгасан байдаг. Тухайлбал: ХАА-н хэлэлцээр зөвхөн тухайн хэлэлцээрт хамрах татаас, дэмжлэг болон бусад арга хэмжээ авах хэрэгслийг ашиглаж зохицуулалт хийх заалтуудыг агуулдаг. Эдгээр заалтад олон орны ХАА-н үйлдвэрлэлийн эмзэг асуудлыг тусгахыг оролдсон.

Үүний зэрэгцээ, улс орнууд үндэснийхээ хэмжээнд гишүүд зайлшгүй дагаж мөрдвөл зохих дотоод журмууд эдгээр хэлэлцээрт багтдаг. Аливаа Гишүүн нь өөр Гишүүний үүрэг амлалтаа биелүүлээгүй явдлыг Гишүүний бодит амлалт, авсан үүрэг хариуцлагаа зөрчсөн хэмээн үзэж, дайрч өдөөж болдог. Иймд эдгээр хэлэлцээрийн ач холбогдлыг дутуу үнэлж болохгүй юм. Энэхүү бараа бүтээгдэхүүний худалдааны тусгай хэлэлцээрт туссан заалтуудад тулгуурлан олон тооны маргаантай асуудал шийдэгдсэн билээ.

худалдааны хэлэлцээр" байгуулдаг. Энэхүү хоёр талын хэлэлцээр нь зөвхөн баталсан гишүүдэд л үйлчилдэг учиртай. Эдгээрээс хамгийн чухал нь гишүүдийн улс, муж, орон нутгийн засаг захиргаа болон төрийн хяналттай аж ахуйн нэгжийн тодорхой бараа, үйлчилгээний ханган нийлүүлэлтийг зохицуулдаг "Засгийн газрын худалдан авах ажиллагааны тухай хэлэлцээр" юм. Мэдээлэл технологийн тодорхой бүтээгдэхүүнд ногдуулсан тарифыг арилгах ерөнхий заалттай "Мэдээлэл технологийн хэлэлцээр"-т саяхнаас зарим гишүүд нэгдэн орсон.

6. Одоо мөрдөгдөж буй ДХБ-ын эрх, үүрэг цаашид өөрчлөгдөх үү?

Анх 1947 онд батлагдсан ТХЕХ-ийн нэгэн адил ДХБ-ын хэлэлцээрт тусгагдсан эрх үүрэг байнга өөрчлөгдөж байдаг. Тухайлбал, Гишүүд улс орныхоо хууль тогтоомжийг өөрчлөх, ДХБ-ын хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулан сайжруулах, хүчин төгөлдөр буй заалтын шинэ тайлбарыг боловсруулж ДХБ-ын хүрээнд өмнө нь хамардаггүй байсан асуудлаар шинэ дүрэм журам гаргах санал боловсруулах ажлыг холбогдох хороодод санал болгох байдлаар эрх үүргийг нь байнга өөрчилж байдаг юм. ДХБ-ын хувьд нийтэд нь хамрах асуудлаар олон талын томоохон хэлэлцээ тогтмол явагддаг. Энэхүү "хэлэлцээний үе шат" гэж нэрлэгддэг олон талын хүчин чармайлт нь ДХБ-ын төрөл бүрийн хэлэлцээрт багтдаг янз бүрийн салбаруудаар худалдааг чөлөөлөх алхам хийдэг юм. ТХЕХ-ийн хүрээнд нийт найман үе шатны хэлэлцээ хийсний сүүлийн үе шат (Уругвайн үе шат)-ад ДХБ-ыг байгуулжээ.

ДХБ-ын ивээл дор томоохон хэлэлцээний үе шатыг эхлүүлэх гэсэн эхний оролдлого 1999 оны 12 дугаар сард Сиэтл хотноо бүтэлгүйтсэн юм. Ихээхэн шуугисан энэхүү бүтэлгүй оролдлогын дараа 2001 оны 11 дүгээр сард ДХБ-ын гишүүд Катарын Доха хотноо болсон гишүүн орнуудын Сайд нарын Бага хурлаар хэлэлцээний шинэ үе шатыг эхлүүлж чаджээ. Энэ хооронд буюу 2000 оны эхээр дэлхийн зах зээлийн үйлчилгээний өргөн хүрээний салбарт нэвтрэх боломжийг илүү нээлттэй болгох, үйлчилгээнд хамаарах шинэ дүрэм журам боловсруулах, ХАА-н хэлэлцээний хүрээнд татаас болон бусад асуудлыг шийдвэрлэх зорилготой хэлэлцээрийн суурь тавигдсан билээ.

7. ДХБ-ын үүрэг хариуцлагыг хэрхэн мөрдлөг болгодог вэ ?

ДХБ-ын хэлэлцээрийн үүрэг хариуцлага нь (хязгаарлагдмал тооны оролцогчидтой худалдааны хоёр хэлэлцээр орохгүйгээр) ДХБ-ын Гишүүн бүрт хамаардаг. ДХБ-ын үүрэг хариуцлагыг ДХБ-ын Гишүүн орнуудын засгийн газар болон Европын холбоо зэрэг этгээдийн төв удирдлагад хүлээлгэдэг. Үүний зэрэгцээ улс орны Засгийн газрын ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг хариуцлага нь Гишүүн тус бүрийн дотоодын орон нутгийн засаг захиргааны хүлээх үүрэг мөн болохыг хэлэлцээрийн эх хувьд зааж

ь тогтоомж нь ДХБ-ын хууль тогтоомжийн дээгүүр гарч, түүнээс олгох итгэйд талыг үгүйсгэх учиргүй юм. Энэ нь ДХБ-ын дүрэм журмын цар эг гарцаагүй өргөтгөж байгаа билээ. Төрийн өмчит аж ахуйн нэгж, ийн хяналтан дор ажилладаг хувийн аж ахуйн нэгжүүдэд хамаарах -ын дүрэм журмыг тэдгээр аж ахуйн байгууллага мөн дагаж мөрдөх эгтэй.

ишүүд хоорондын маргааныг хэрхэн шийдвэрлэдэг вэ?

алдааг улам бүр чөлөөтэй болгох ДХБ-ын дүрэм журмын суурь онол дэлхийд хуримтлагдаж буй баялгаас бүх талуудад хүртээх гэсэн ааг агуулдаг. Гэвч дотоодын улс төрийн дарамт шахалт, нөөцийн аарлагдмал байдлаас шалтгаалан гишүүд үүргээ бүрэн биелүүлэхээс лхийх явдал үе үе гардаг юм. Зөрчилтэй асуудлыг шийдвэрлэхэд тэсэн ДХБ-ын бодлого нь гишүүдийн маргаанд харилцан сэтгэл амжтай шийдэл олохыг оролддог билээ. Тиймээс ДХБ-ын маргаан идвэрлэх дотоод журам нь харилцан зөвлөлдөх явдлыг маргаан цуулах хамгийн зохистой арга гэж онцлон үздэг.

илцан тохирох шийдэлд хүрж чадахгүй аваас ДХБ-ын маргаан идвэрлэх албан ёсны механизм үйлчилдэг. Энэхүү механизмыг ргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулах дүрэм, журмын тухай илцан ойлголцох баримт бичиг" (МШББ)-т заасан юм

агаан шийдвэрлэх байгууллагын бүтэц, зохион байгуулалт, хэлэлцэх ийг "МШББ"-т заадаг. МШББ-ын дагуу маргааныг албан ёсоор идвэрлэх үйл явцын үр дүн нь маргаанд оролцогч талуудад үүрэг дог онцлогтой.

-ын маргаан шийдвэрлэх үйл явцын хамгийн чухал шинж чанар бол үүдийн маргаан шийдвэрлэх хөндлөнгийн хэсэг байгуулах санал гах эрх, заавал үүрэг болгож заасан хугацаанд шийдвэр гаргуулах эрх, гаан шийдвэрлэх хөндлөнгийн хэсгийн шийдвэрийг байнгын үйл ллагаатай Давж заалдах газарт⁷ өргөдөл гаргаж давж заалдах эрх, ээр шийдвэрийг олон улсын хуулийн адил ДХБ-ын гишүүдэд үүрэг гон бараг шууд батлуулдаг явдал юм.

нөх ТХЕХ-ийн маргаан шийдвэрлэх үйл явцад ийм зүйл ороогүй сан. Албадан гүйцэтгүүлэх эрх үүргээс бүрдсэн эрх зүйн тогтолцоог болгосон явдал ДХБ-ыг шинээр бүрэлдүүлэх явдлын амжилтад асар үрэг гүйцэтгэж байгаа юм.

ББ-ын дагуу маргаан шийдвэрлэх явцын эхний үе шатанд маргалдаж Гишүүдийг хооронд нь зөвлөлдүүлдэг. Зөвлөлдөх үедээ маргалдаж Талууд ДХБ-ын дотоод журам, маргаан шийдвэрлэх дүрмийг мөрдөх ой. Зөвлөлдөө хийх хүсэлт гаргасан Тал нь тогтоосон цаг хугацаанд

багтаж өөрийн зүгээс хүлээн зөвшөөрөхгүй байгаа нөгөө талын ар хэмжээ болон хуулийн маргаантай асуудлыг тодорхойлох ёстой байдаг. Энэхүү зөвлөлдөх үйл явцын үед нууцыг чандлан хадгалах ёстой боловч тухайн хэлэлцэж буй асуудлаар ДХБ-ын бусад гишүүдийн худалдаан эрх ашиг ноцтой хөндөгдөж байвал хариуцагч Тал зөвшөөрсн тохиолдолд тэднийг энэ явцад оролцуулж болно.

Харилцан зөвлөлдөх үйл явц үр дүнд хүрээгүй тохиолдолд гомдлогч гаргагч тал албан ёсны шүүхийн үйл явцыг эхлүүлэх хүсэлт тавьж болдог. Гомдол гаргагч тал нь ДХБ-ын маргаан шийдвэрлэх хөндлөнгийн хэсэг байгуулах хүсэлт тавьснаар энэ үйл явц эхлэнэ. Хөндлөнгийн хэсгийн бүрэлдэхүүний талаар харилцан зөвшилцөж чадаагүй тохиолдолд Талууд бүрэлдэхүүнийг сонгодог аж.

Хөндлөнгийн хэсэг асуудал хэлэлцэн шийдвэрлэх ажлыг тодорхой заасан хугацаанд явуулдаг. Хөндлөнгийн хэсэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх явцын хүрээнд Талууд зөвшилцөн тохирч, хоорондоо мэдээлэл солилцож, хөндлөнгийн хэсэгт албан ёсоор товч танилцуулга хийдэг. Асуудлыг хэлэлцсэний дараагаар хөндлөнгийн хэсэг гаргасан шийдвэр Талуудад болон Маргаан шийдвэрлэх байгууллагын⁸ (МШБ) үүргийг гүйцэтгэж буй ДХБ-ын нэгдсэн гишүүнчлэлд батлуулахаар танилцуулдаг. Маргалдаж буй талууд багтан ордог МШБ-ын бүх гишүүд шийдвэрийг санал нэгтгэйгээр хүлээн аваагүй тохиолдлоос бусад үед МШБ-аар батласан шийдвэр нь бүх талуудад үүрэг хүлээлгэдэг. Хуучин ТХЕХ-ээр ямарваа нэг гишүүн аливаа шийдвэрийг батлах үйл явцад тодорхой бусад хугацаагаар хориг тавьж, шийдвэр гаргах явцыг хойшлуулдаг байсанг харьцуулахад дээрх өөрчлөлт нь нэн чухал ач холбогдолтой юм.

Талууд хөндлөнгийн хэсгийн шийдвэрийг бүгд хүлээн зөвшөөрөхгүй байвал Давж заалдах газарт даван заалдаж болдог. Давж заалдах газар нь МШБ-ын дөрвөн жилд нэг удаа сонгодог 7 хүний бүрэлдэхүүнт байнгын бүлэг юм. Давж заалдах газар комиссын гаргасан шийдвэрт холбоотой даван заалдах хурлыг хуралдуулдаг. Комиссын шийдвэрийг нэгэн адил Давж заалдах газраас гаргах шийдвэрийг МШБ-аар баталдаг ба бүх гишүүд шийдвэрийг хүлээн авахаас санал нэгтгэйгээр татгалзсан үед л уг шийдвэр хүчингүйд тооцогдоно.

Хөндлөнгийн хэсэг, эсхүл Давж заалдах газраас гаргасан эцсийн шийдвэрийг Талууд биелүүлэх ёстой. Хариуцагч Тал уг хэрэгт ялагдсан тохиолдолд худалдааны хориггоо болиулах, эсхүл зөрчилтэй арга хэмжээ авахаас зайлсхийх явдлыг ДХБ-ын хүрээнд хүлээх үүргийн заалт биелүүлж, хуулийн зөрчлийг шийдэх илүү зохистой арга гэж үздэг. Ялагдал хүлээсэн хариуцагч Тал нөгөө талдаа нөхөн төлбөр хийж байдлаар үүргээ биелүүлж, дүрэм журмаа дагах боломжтой хэдий үүнийг түр зуурын арга хэмжээ гэж үздэг. Зөрчил гаргасан Тал тухайн арга хэмжээг дүрэм журамд нийцүүлэх байдлаар залруулах, эсхүл нөхөн төлбөр хийхээс татгалзвал гомдол гаргасан Тал тухайн хууль ё

⁸ Dispute Settlement Body - DSB

учирсан хохиролтой тэмцэх хэмжээний худалдааны сөрөг арга зах байдлаар хариу арга хэмжээ авч болдог.

н албадан мөрдүүлэх дүрэм үр дүнтэй байж чадсан уу?

тээгдэхүүний чөлөөт худалдааг бий болгох зорилготой ТХЕХ-илтыг ДХБ-ын тогтолцоо эрчимтэй хөгжсөн явдалтай холбож 195 оноос хойш ДХБ-ын Гишүүд, шинээр нэгдэн орох өргөдөл этгээдийн тоо байнга өсөж, бараа үйлчилгээний салбарын н дэлхий даяар илүү чөлөөтэй болон, санхүүгийн үйлчилгээ, а холбооны салбарыг багтаан өргөжиж ирсэн бөгөөд худалдаа р чөлөөтэй болж байна. Эцэст нь, маргаан шийдвэрлэх шинэ о ДХБ-ын дүрэм журмыг хэрхэн тайлбарлан биелүүлэх явдлыг даас илүү сайн мэдэхэд тус дөхөм болж байна. Дүрэм журмыг пах асуудлаар дэгдсэн ДХБ-ын томоохон Гишүүд хоорондын улс төржсөн цөөн хэдэн маргаан нь албадан биелүүлэх асуудалд төрүүлж байсан боловч энэ нь түгээмэл биш юм. Гишүүд МШББ- хүлээлгэх мөн чанарыг хүлээн зөвшөөрсөн ба ДХБ-ын тууштай йдалд авах арга хэмжээг⁹ хамгаалах гэж хөрөнгө нөөц ахдаа дурамжхан байдаг тул албадан мөрдүүлэх асуудлын олонхийг албан бус, энгийн байдлаар шийдвэрлэж байгаа. н мөрдүүлэх шаардлагатай илүү хүндрэлтэй асуудлын хувьд лштай бус арга хэмжээг арилгах үүднээс гишүүд ихэнх олд Хөндлөнгийн хэсэг болон Давж заалдах газрын шийдвэрт дэг маргаан шийдвэрлэх механизмыг амжилттай хэрэглэж ирлээ.

н-ын дүрэм журам хувийн компаниудад яагаад чухал вэ?

л хувийн компаниудын үйл ажиллагаанд нөлөөлөх нь улам бүр жж буй харьцангуй шинэ байгууллага юм. Компаниуд өөрсдийх нь иллагаанд ДХБ ямар холбоотой болохыг одоогоор бүрэн ойлгохгүй олно. Харин ДХБ-аас тогтоодог дүрэм журмын үр нөлөө цаашид рдрох юм. Ирээдүйд компаниуд дөрвөөс доошгүй зүйлээр ДХБ-тай их болно. Үүнд: (1) дотоодын шүүх үйл ажиллагаа, (2) олон улсын н шийдвэрлэх явц, (3) дотооддоо дүрэм журам боловсруулах үйл (4) олон улсын хэмжээнд дүрэм журам боловсруулах үйл явц а.

ХБ-ын дүрэм журам ба бизнес төлөвлөлт

чи нь арилжааны үйл ажиллагааны стратегиа боловсруулахдаа зах нэвтрэх боломж, хөнгөлөлттэй тариф, тусгай зөвшөөрөл олгох лага, хил нэвтрэх шалгалт, стандарт хүлээн зөвшөөрөх зэрэг чухал ыг харгалзаж үзэх хэрэгтэй болдог. Зорьж буй зах зээлийнхээ

худалдаа, хөрөнгө оруулалтын суурь хүрээг няхуур судалж чадаагүй бол аливаа компани цаг хугацаа, хөрөнгө мөнгөө алдахад хүрч болно. Гэхдээ ДХБ-аас боловсруулан гаргадаг хуулинд үүнийг сайтар тусгасан байвал экспорт, эсхүл арилжааны ярвигтай гүйлгээтэй холбоотой худалдаа, хөрөнгө оруулалтын эрсдлийг багасгахын тулд компани нь ДХБ-ын дүрэм журам болон дотоодод хэрэгжүүлэх тайлбар ойлголтыг ашиглаж болох учиртай.

Богино болон урт хугацааны бизнес төлөвлөлт, хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг сайжруулахад ДХБ-ын дүрэм журмын гүйцэтгэсэн үүргийн талаар олон жишээ байдаг. Тухайлбал, ТХЕХ-ийн хүрээнд Гишүүн тус бүр тарифын дээд түвшингээ тогтоож, тоон хязгаарыг арилган, барааны худалдаа зохицуулалтад аливаа ялгаварлан гадуурхах байдлаас зайлсхийх үүрэг амлалт авдаг. Мөн үйлдвэрийн газар, эсхүл түгээх төвийн байршлыг тогтооход бүс нутгийн худалдааны хэлэлцээрт Гишүүний оролцсон байдал шийдвэрлэх ач холбогдолтой байж болно. Тухайн бүтээгдэхүүнийг ямар улсад үйлдвэрлэснээс хамааран тариф ногдуулах, эсхүл хөнгөлөлттэй нөхцөл үзүүлэх асуудлыг харилцан адилгүй шийдвэрлэдэг тул улс орны барааны гарал үүслийн журам¹⁰ импорт эрхлэгчдэд санхүүгийн ихээхэн учир холбогдолтой болж ирнэ. Гадаадын үйлчилгээ нийлүүлэгчдэд тухайн улсын зах зээл хир нээлттэй байх, тухайн үйлчилгээ ба үйлчилгээ үзүүлэгчдэд дотоодын үйлчилгээ ба үйлчилгээ үзүүлэгчдийн адил нөхцөл үзүүлэх эсэхийг Гишүүн бүрийн ҮХЕХ-ийн өмнө авсан үүрэг амлалт харуулдаг. Өөр нэг Гишүүн улс орны засгийн газраас зарласан гэрээт ажил гүйцэтгэх тендерт бэлтгэх явцдаа Засгийн газрын худалдан авах ажиллагааны тухай хэлэлцээр¹¹ (ЗГХААХ)-т тухайн Гишүүн гарын үсэг зурж нэгдсэн эсэхийг харах байдлаар аливаа пүүс компани тухайн гэрээг гүйцэтгэх нь ашигтай эсэхийг тогтоох үнэлгээ хийж чадна. ЗГХААХ-ийн хүрээнд заасан дотоод журам болон тухайн гэрээт ажлын тендер зарлаж буй улс орны энэхүү хэлэлцээрээр авсан бодит үүрэг амлалт нь тухайн уралдаанд оролцох, эсэхэд дүгнэлт хийх боломж олгодог.

ДХБ-ын дүрэм журам аж ахуйн нэгжийн түвшинд хувь хүний ашиг сонирхолд хэрхэн шууд нөлөөлдөг жишээний цөөхөн хэдийг л дээр дурьдлаа. Дээрх болон тоо тоймшгүй бусад олон асуудал нь өдөр тутмын бизнес төлөвлөлтөнд холбоотой бөгөөд олон улсын маргаан шийдвэрлэх асуудалд огт хамаардаггүй юм. ДХБ-ын хууль дүрэмтэй олонтаа холбож тайлбарладаг, хэвлэл мэдээллээр ихээхэн шуугисан өндөр түвшний маргааны асуудлаас илүү дээрх асуудал нь хувь оролцон тоглогчдод ач холбогдолтой билээ.

10.2. ДХБ-ын дүрэм журам ба дотоодын шүүх ажиллагаа

Хувь хүмүүс өөрийн орны шүүхэд хувийн чанартай эрх зүйн асуудлааг шийдвэрлүүлэхдээ улс орныхоо ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтыг

¹⁰ Rules of origin

¹¹ Agreement on Government Procurement - 'GPA'

шүүхээр хэлэлцэхээс татгалзах, эсхүл асуудлыг тусгалгүй орхих явдал ихэнх тогтолцоонд гардаг юм. Гэвч зарим улс орны шүүхээр "тууштай тайлбарлах" номлол¹² хэрэглэж, дотоодын хуулиа тухайн улсын олон улсын хуулиар хүлээх үүрэгтэй холбон тайлбарладаг. Аливаа хувь этгээд өөрийн улсынхаа шүүхэд ийм номлол хэрэглэхийг уриалах замаар ДХБ-ын өмнө улсынхаа хүлээсэн үүрэгт нийцэх байдлаар дотоодын хуулийг хэрэглэнэ гэж улсынхаа шүүхийг тайлбарлуулахаар ятгаж болох юм. Үүний нэгэн адил ямарваа нэгэн хувь этгээд өөрийн орны шүүхэд ДХБ-ын Хөндлөнгийн хэсэг, Давж заалдах газрын холбогдох байр суурийг ишлэл татах замаар дотоодын хэрэгт нотлох баримт болгон ашиглаж болно.

10.3. Олон улсын шүүх ажиллагаа: ДХБ-ын Маргаан шийдвэрлэх тогтолцоо

ДХБ-ын төрөл бүрийн хэлэлцээрт орсон үүрэг амлалтыг ДХБ-ын Гишүүд дагаж мөрдөх ёстой байдаг. Мөн дотооддоо бүс нутаг, орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагааг эдгээр үүрэг амлалтын хүрээнд нийцүүлэх үүргийг Гишүүд хүлээдэг. Эдгээр үүрэг амлалтыг биелүүлээгүй юмуу, эсхүл зөрчсөн тохиолдолд уг асуудлыг шийдвэрлүүлэхээр өөр нэг Гишүүн ДХБ-ын маргаан шийдвэрлэх тогтолцоонд хандаж болно. Маргаан шийдвэрлэх явцын санаачилгын ард хувийн компани чухал үүрэг гүйцэтгэж болох бөгөөд энэ явцдаа засгийн газартаа ихээхэн туслалцаа үзүүлэх боломжтой.

Хувь этгээд маргаан шийдвэрлэх явцад үндсэн хоёр үүрэг гүйцэтгэж болно. Нэгдүгээрт, шууд бус уламжлалт үүрэг, хоёрдугаарт, саяхнаас хүлээн зөвшөөрөгдсөн шууд үүрэг орно.

ДХБ-ын хүрээнд зөвхөн Гишүүд бие биендээ гомдол гаргаж болдог тул, олон улсын маргаан шийдвэрлэх үйл явцад хувь этгээдийн гүйцэтгэх уламжлалт үүрэг нь маргаан шийдвэрлэх үйл явцад бэлтгэх шатанд шаардлагатай мэдээллийг бүрдүүлэх, хэргийг бэлтгэхэд оролцох албан бус түнш байхад оршдог. ДХБ-ын дүрмийг өөр нэг Гишүүн зөрчиж болзошгүй байгаа тухай улс орныхоо эрх бүхий хүмүүст хувь этгээдүүд л гол төлөв мэдээлдэг. Засгийн газар нь уг гомдлыг судалж, албан бус зөвлөлдөөн хийх, эсхүл ДХБ-ын маргаан шийдвэрлэх журмын хүрээнд албан ёсны зөвлөлдөөн хийх хүсэлт тавих шийдвэр гаргаж болно. Зах зээлийн орчинд дүрэм журам хэрхэн үйлчилдэг талаар хувийн аж ахуйнууд мэдлэгтэй байдаг бөгөөд, тэд өрсөлдөөний нөхцөлтэй холбоотой аливаа бэрхшээлийг олж илрүүлэхэд хамгийн тохиромжтой байр сууринд байдаг тул энэхүү үүрэг нэн чухал юм.

¹² The doctrine of "consistent interpretation"

баидлаар туслалцаа үзүүлж болдог. Ямар асуудлаар гомдол гаргах, зөвлөлдөөний үе хийгээд улмаар асуудлыг хөндлөнгийн хэсгээр хэлэлцэх үед ямар стратеги баримтлах талаар хувь этгээдтэй хамтран ажиллах нь улс орны засгийн газарт үлэмж ач холбогдолтой байх нь олонтай. Энэ нь засгийн газарт аливаа хэрэг бүрдүүлэхэд зарцуулах цаг хугацаа, нөөц хязгаарлагдмал байдагтай холбоотой юм.

Эцэст нь, маргаан шийдвэрлэх үйл явцын шийдвэрийн хэрэгжилт нь шүүн хэлэлцэх үйл ажиллагаагаар зогсохгүй, түүний дараа эхлэдэг тул чухамхүү энэ үед анхаарал сулрах нь олонтай тохиодог. Иймд Хөндлөнгийн хэсэг болон Давж заалдах газрын шийдвэрийн биелэлтэнд хяналт тавихад хувь этгээдүүд үнэлшгүй их үүрэг гүйцэтгэж чаддаг.

Хувийн аж ахуйн байгууллага нь гарсан өөрчлөлтийг ажиглах, тухайн зах зээлийн нөхцөлд уг өөрчлөлтийн үзүүлж буй нөлөөнд ажиглалт хийх хамгийн тохиромжтой байр сууринд байдаг. Хэрэв нөхцөл байдал сайжрахгүй байвал тухайн хувь хүн асуудлыг эрх бүхий байгууллагаар эргэн хянуулах үүднээс анхаарлыг нь хандуулах ёстой. Зах зээлийн нөхцөл байдал ДХБ-ын шийдвэртэй зөрчилдөж болзошгүй байгаа тухай дэлгэрэнгүй цогц мэдэгдэл гаргах явдал нь засгийн газрын зүгээс хүлээсэн үүргийнхээ хэрэгжилтийг эргэж хянахыг ятгаж чадах үнэлшгүй арга байж болох юм.

ДХБ-ын маргаан шийдвэрлэх үйл явцад хувь этгээдийн гүйцэтгэх хоёр дахь буюу саяхан нэвтрүүлсэн үүрэг бол шийдвэр гаргагчдад мэдээлэл шууд өгөхөд орших юм. Хувийн компани, холбоо, ашиг сонирхлын бүлгээс гаргаж өгсөн "шүүхийн найз"-ын захидал, эсхүл *amicus curiae* товч танилцуулга нь тодорхой хэргүүдээр гарах шийдвэрт цаашид илүү нөлөөтэй байж болно. МШББ-ын заалтанд ДХБ-ын комисс *amicus curiae* товч танилцуулгыг авч үзэх эсэх нь тодорхой бус байгаа. Гэвч Давж заалдах газрын журамд маргалдаж буй асуудалтай холбоотойгоор эдгээр товч танилцуулгыг баримт болгох, эсхүл хуулийн зүйлтэй нь холбоотойгоор мэдээллийн эх үүсвэрээр үзэх эсэх нь маргаан шийдвэрлэх Хөндлөнгийн хэсэг болон Давж заалдах газрын шийдэх асуудал гэж заасан юм. Энэ шийдвэр нь засгийн газар нөгөө талын засгийн газартай маргалдах үед хувийн ашиг сонирхлын бүлгүүдэд мэдээллээр хангах боломжийг нээж өгч байгаа юм. Гэвч маргаанд оролцож буй засгийн газрын аль нэг тал хувь этгээдийн гаргасан мэдээллийг албан ёсоор авсан тохиолдлоос бусад үед Хөндлөнгийн хэсэг, Давж заалдах газар хувь этгээдийн мэдээллийг авч үзэхдээ нэн дурамжхан байдгийг өнгөрсөн туршлага харуулсан билээ.

Түүнчлэн ДХБ-ын Хөндлөнгийн хэсэг болон Давж заалдах газраас гол зүйл заалтыг хэрхэн тайлбарлаж байгааг болон тэдгээрээс гарах шийдвэрийг судлан, ажиглах замаар хувь этгээд өөртөө ашиг гаргаж болно. Хувь этгээд маргаанд шууд оролцоогүй байсан ч тухайн зүйлийг

эн тайлбарлахаас хамааран түүний үйл ажиллагаа, төлөвлөлтийн энд ашигтайгаар юмуу эсхүл алдагдалтайгаар тусч болох талтай. Илбал, ДХБ-ын Хөндлөнгийн хэсэг, Давж заалдах газар нь гол төлөв ин худалдааны байгууллагад тавьж буй нөхцөл, экспортод татаас х дүрэм журам, хөдөө аж ахуй, хүнсний генетикийн хувиралд лсан бүтээгдэхүүний шошго болон олон тооны бусад асуудлаар дээр гаргадаг.

. Хууль боловсруулах үйл явцад нөлөөлөх буюу бодлогын өөлөл¹³

пани таалагдахгүй дүрэм журамтайгаа халз тулгарахаас нааш цуулалтаас бусад өрсөлдөөнтэй бизнесийн орчны дарамт шахалтад зарлаа хандуулахгүй байх нь олонтой. Батлан гаргадаг дүрэм журамд нөлөөлөх үүднээс зохицуулалтын үйл явцад оролцож байх нь дээр даг юм. Энэ нь ДХБ-ын дүрэм журам боловсруулахад ч мөн хамаатай. ид ДХБ-ын дүрэм журам боловсруулах үйл явцад нөлөөлөх явдал нь ийн хэвшилд хамаарах дөрөв дэх асуудал болно. Чингэснээр хувийн пани нь хууль эрх зүйн болон зохицуулалтын дарамтаа багасгаад, зах тийн олон дүрэм журам, стандартыг уялдуулан зохицуулж үр ашгийг жруулах ба юуны түрүүнд шинэ болон одоогийн зах зээл дэх луулалт, хөрөнгө оруулалтын боломжийг тогтоох боломжтой болдог.

эм журмыг боловсруулахад нөлөөлөх хүчин чармайлтыг хоёр хүрээнд түүлж болно. Үүнд: 1-т, улсынхаа засгийн газрын өмнө өмгөөлөл улах ба 2-т, олон улсын түвшинд ДХБ-ын төлөөлөгчдийн өмнө өөлөл хийх явдал ордог. Томоохон компаниудад танил энэ хоёр ачлал нь жижиг аж ахуйн нэгж болон аж ахуйн нэгжийн бүлэглэлд ч и чухал юм.

5 бол гишүүдийн хүсэлтээр явдаг байгууллага юм. Өөрөөр хэлбэл, цүүд нь аливаа арга хэмжээ авах санал гаргаж, тэд шийдвэр гаргадаг. Б-ын Нарийн бичгийн дарга нарын газар хэдийгээр нөлөөтэй ч цүүдийн хүслийн эсрэг арга хэмжээ авч чадахгүй. Маргаан идвэрлэх Хөндлөнгийн хэсэг, Давж заалдах газар нь одоогийн мөрдөж и хэлэлцээрүүдийг тайлбарлах эрхтэй ч, Гишүүдийн хүлээж буй гол иг, тэдэнд ногдуулах ачаа дарамтыг өөрчилж чадахгүй. Энэхүү хүртэх иг, үүрэх ачаанд өөрчлөлт оруулах шаардлага гарвал улсынхаа ишинд өмгөөллийн хүчин чармайлт тавих нь ихээхэн ашигтай байж лно. ДХБ-ын тогтолцоог бүхэлд нь авч үзэн, цогц санал боловсруулж йгаа тохиолдолд ДХБ-д тодорхой байр сууриа илэрхийлж, түүнийгээ ижихэд нь засгийн газраа хөхиүлэн дэмжих явдал хамгийн үр дүнтэй йж болно. Хувийн аж ахуйн нэгж өөрийн орныхоо холбогдох эрх мэдэл кий байгууллагад саналаа танилцуулж, тухайн байгууллага нь саналыг энев дэх холбогдох хүмүүстээ уламжлан ДХБ-д албан ёсоор тавьж лдог. ДХБ-ын төлөөлөгчид ихэнх тохиолдолд ажлын хэт их ачаалалтай

байдаг тул ДХБ-д олон улсын худалдааны тухай хуулийг боловсруулах үед нэг пүүс компани, эсхүл пүүс компанийн бүлгийн сайн найруулгатай, цогц , тодорхой зорилго чиглэл бүхий өмгөөлөл ихээхэн үр дүнд хүргэдэг.

Олон улсын хэмжээнд ч хувийн аж ахуйн нэгж үүнтэй төстэй үүрэг гүйцэтгэж болно. ДХБ-ын томоохон хэлэлцээний үе шат хэдэн жилд нэг удаа явагддаг боловч дүрэм журам боловсруулах явдал нь ДХБ-ын өдөр тутмын гүйцэтгэдэг ажил юм. Хувийн компани бие даан юмуу, эсхүл олон улсын нийгэмлэгээр дамжуулан ДХБ-ын ажлын хэсэг, Женев дэх улсынхаа төлөөлөгчидтэйгээ холбоо тогтоон тодорхой саналаа уламжлах, мэдээлэл өгөх зэргээр олон улсын худалдааны хууль дүрмийг зүй зохистой болгоход нөлөө үзүүлж болно. Мөн Гишүүдийн хэлэлцэж буй асуудалтай холбоотой зохион байгуулагдах улсын ба хувийн хэвшлийн хоорондын зөвлөлгөөнд аливаа компани оролцож болно. Үүнд мөн л адил ДХБ-ын тогтолцооны бусад хэсэгт өрнөж буй үйл явдалтай уялдсан, сайтар найруулж, боловсруулсан цогц санал ДХБ-ын дүрэм журам боловсруулах үйл явцыг бүрдүүлэн тогтооход үнэлшгүй чухал ач холбогдолтой байж болно. Ялангуяа, ДХБ-ын хэлэлцээнд хувь этгээдийн оролцоог Америкийн Чөлөөт худалдааны бүсийн хэлэлцээр, эсхүл Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) орнуудын хооронд чөлөөт худалдаа хийх хэлэлцээ зэрэгт ашигтай дүрэм журам, нөхцөл бүрдүүлэх үүднээс олон талын хүрээнд лобби явуулах ажилтай хослуулж болох юм.